

Санамж: Энэхүү үйлчилгээний нөхцөл нь “КОВИД-19 ба онцгой нөхцөл байдлын үеийн арга хэмжээнүүдийн тухай” **вэбинарт оролцогч нарт ойлголт өгөх, жишээ болгож бэлдсэн мэдээлэл бөгөөд Өмгөөллийн “ХаанЛекс Партнерс” ХХН-ийн зүгээс боловсруулсан, хүргүүлсэн хууль зүйн мэргэжлийн зөвлөх үйлчилгээ биш болно.**

ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

2020 оны 12 сарын
24-ний өдөр

Улаанбаатар хот

Энэхүү Хөдөлмөрийн Гэрээний Нэмэлт Өөрчлөлт нь 2020 оны 1 сарын 1-ний өдөр нэг талаас ажил олгогч ХаанЛекс ХХК (цаашид **“Ажил олгогч”** гэх) нөгөө талаас ажилтан Учрал (цаашид **“Ажилтан”** гэх ба “Ажил олгогч” болон **“Ажилтан”** нарыг хамтад нь **“Талууд”** гэх) нарын хооронд байгуулсан 1021 тоот Хөдөлмөрийн гэрээ (цаашид **“Үндсэн гэрээ”** гэх)-ний нэмэлт өөрчлөлт (цаашид **“Нэмэлт өөрчлөлт”** гэх) болно.

КОВИД-19 цар тахал Монгол улсад тархсан, цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээ хэрэгжүүлэх үүднээс Монгол улсын засгийн газар, эрх бүхий байгууллагаас “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал”, “Бүх нийтийн бэлэн байдал”-ын зэрэглэлд шилжүүлэх, хорио цээрийн, хөдөлгөөний хязгаарлалтын, тусгаарлалтын дэглэм тогтоох зэрэг авсан арга хэмжээтэй холбогдуулан, Иргэний хуулийн 189.1, 220.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 21.6, 23, 24, 35.1.7, 48.3.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34.1.2, 34.2.2, 34.2.5-д заасныг үндэслэн гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, хорио цээрийн дэглэм бүхий нөхцөл байдалд хөдөлмөрийн харилцааг зохицуулах зорилгоор дараах нөхцөлийг тохирч байгуулав. Үүнд:

1. Монгол улсын засгийн газар, эрх бүхий байгууллагаас гаргасан “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал”, “Бүх нийтийн бэлэн байдал”-ын зэрэглэлд шилжүүлэх, хорио цээрийн, хөдөлгөөний хязгаарлалтын, тусгаарлалтын дэглэм тогтоох, хөл хорио тогтоох зэрэг нь Талуудын хувьд давагдашгүй хүчин зүйл мөн болохыг Талууд харилцан ойлголцож, хүлээн зөвшөөрч байна.
2. Ийнхүү давагдашгүй хүчин зүйл тохиосонтой холбогдуулан Ажил олгогчийн үйл ажиллагаа тодорхойгүй хугацаагаар зогсож, давагдашгүй хүчин зүйл арилах хүртэлх хугацаанд Ажилтанд цалингүй чөлөө олгохоор тохиролцов.
3. Ажил олгогч нь чөлөөтэй байгаа Ажилтны ажлын байрыг дээрх хугацаанд хэвээр хадгална.
4. Ажилтанд чөлөө олгосонтой холбогдуулан 200,000 төгрөгийн тэтгэмж нэг удаа олгох ба чөлөөтэй хугацаанд олговор олгохгүй.
5. Ажил олгогч нь Ажилтны чөлөөтэй байх хугацааны нийгмийн даатгалыг Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (420,000 төгрөг)-ээс тооцож Нийгмийн даатгалын санд бүрэн хэмжээгээр төлнө.
6. Давагдашгүй хүчин зүйлийн нөлөө арилсан нөхцөлд Ажил олгогч Ажилтанд энэ талаар мэдэгдэх бөгөөд Ажилтан ажлын байрандаа мэдэгдэлд заасан хугацаанд ирж ажил, үүргээ үргэлжлүүлэн ажиллана.
7. Давагдашгүй хүчин зүйлийн нөлөө арилж, Ажилтан ажлын байрандаа хэвийн нөхцөлд ажиллаж эхэлсэн бол энэхүү Нэмэлт өөрчлөлтийн нөхцөл дуусгавар болж, Үндсэн гэрээний нөхцөл үргэлжлэн хэрэгжинэ.

Энэхүү Нэмэлт өөрчлөлт нь Үндсэн гэрээний салшгүй хэсэг бөгөөд Талууд доор гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлнэ.

НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ БАЙГУУЛСАН:

АЖИЛ ОЛГОГЧ:

АЖИЛТАН:

Гарын үсэг: _____

Гарын үсэг: _____

Нэр, албан тушаал:

Нэр: